

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр +26  
Шөнө +15

SPEAK OUT

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЭРХ МЭДЛИЙГ ХЯЗГААРЛАХ НЬ БУРУУ

ДЭЛХИЙ

“ПХЕНЬЯН ТҮРҮҮЛЖ ПУУЖИН ХАРВАХАД, ДАЙН ЭХЭЛНЭ”

V нүүрт

VIII нүүрт

Дугаарын **60** мөр

ҮЗЭЛ БОДОЛ

“Ажилдаа ирж байна уу, зүүн эргэж чадахгүй л явна”

Ч.ЧУЛУУН

Энэ бол өчигдөр ард түмний дунд үүссэн нөхцөл байдал. Олон ч хүн зүүн эргэлтийн учрыг олох гэж бухимсан байж таарна. Би тэдний нэг. Хувьдаа унаа тэрэгтэй улсын тухайд зүүн эргэх нь тэгтлээ бухимдах зүйл биш байсан байж мэднэ. Хичээл сургууль эхлээгүй болохоор тойрч, тойрч явсаар ямар нэг байдлаар төв замыг гаталсан байж таарна. Харин улсын унаатай жирийн иргэд чиглэл маршрут нь өөрчлөгдсөн автобусныхаа учрыг олохгүй өглөөгүүр автобусны буудал бүхэн дээр ямар чиглэлийн унаанд суу-вал зорьсон газраа хүрэх эсэхээ биеэсээ сураглан хэсэг бужигнаад авсан. Миний тухайд өглөө бүр “Зайсан-Дэнжийн мянга” чиглэлийн автобусанд суусан л бол 40 минутын дараа ажлынхаа үүдэнд шахам буудаг байлаа.

Үргэлжлэл нь III нүүрт

Н.ПУНЦАГБОЛД

Улс төр яг одоо буцалж байна. Энэ халуунд өртөөгүй улс төрийн хүчин, нам эвсэл, гишүүн ховор байх. Хоёр том намаас авахуулаад МАХН-д хүртэл энэ халуурал нөлөөлж эхэллээ. Гэхдээ хамгийн их халуунтай, буцалж байгаа нам нь МАН. Хэзээ мөдгүй дэлбэрэх гэж байгаа галт уул шиг болчихсон энэ намд шийдэх асуудал чамгүй их байна. Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө босч ирж, олон ч нотлох баримтаар батлагдчихаад байгаа 60 тэрбумын хэрэг. Дараа нь дарин дээр давс асгахын үлгэрээр Шадар сайдыг мөрдсөн, мөшгөсөн асуудал босч ирэв. Ингээд л эвтэй байхыг он удаан жил уриалж, сонгууль болгоноор лоозогнож явсан МАН-ын дотоод толхилцоон тэсэрг, одоо дэлбэрэх дээрээ тулчихлаа. Төрийн албыг 60 тэрбумаар зарж, мөнгө босгох ажиллагаанд оролцсон байж болзошгүй хүмүүсийн нэр аль хэдийнэ тодорхой болчихсон. Янз бүрийн баримт ч гарч ирсээр байна. Дээрээс нь хууль хяналтын байгууллагаас энэ хэргийг шалгах ажлын хэсэг гаргачихсан. Улмаар 60 тэрбумыг босгох ажиллагаанд өртсөн байж болзошгүй албан тушаалтнуудыг байцааж эхэлсэн сурагтай. Байцаалт ч нэлээд хатуу болж, зарим нэг хүн амаа бага сага нээсэн гэх

мэдээлэл ч гараад байгаа. Гэхдээ энэ бол албан бус мэдээлэл. Хамгийн сүүлд өнгөрсөн даваа гарагт өнөөх алдарт 90 минутын бичлэгээс илүү ноцтой 40 минутын бичлэг ил боллоо. Бас л цоо шинэ баримт. Төрийн албыг бүр УИХ-ын гишүүн, Улаанбаатар хотын Засаг даргын суудлаас нь авахуулаад зарна гэж төлөвлөсөн тэр этгээдийн ярьж хэлж байгааг монголчууд нийтээрээ сонслоо. Ямар увайгүй юм бэ гэдгийг нь ч харлаа. Тэрийг нь дэмжээд инээгээд сууж байгаа хүн нь ч гэсэн зөвхөн намаа бодсон, амин хувийн ашгаа дээдэлсэн гэдгийг ч мэдэрсэн байх. За тэгээд асуудал цаашлаад улам л гүнзгийрнэ. Шадар сайдыг мөрдсөн, дагасан, “аалз”, “халиар” болгож байгаа асуудал ч МАН-ыг үнэхээр муухай харагдуулж байна. Хэдэн хүнийг бариад хорьчихсон л байгаа. Гэхдээ хэн дага гэж тушаасан, ямар заавар ирсэн бэ гэдгийг ухаж төнхвөл асуудал бүр ч ноцтой болно. Ядаж байхад МАН-ынхан Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр өөрсдийнхөө хийсэн бичлэгийг дотроосоо алдаж, нэлээд эвгүй байдалд орчихоод байна.

Төгсгөл нь III нүүрт



## МАН ХЭЗЭЭ МӨДГҮЙ ДЭЛБЭРЭХ НЬ

OMEGA

Speedmaster  
38 mm

Ω  
OMEGA

OMEGA Boutique: Central Tower, Sukhbaatar Square, 2nd Floor, Tel: 9963-9494

Omega\_HQ • Visual: SP22\_324.28.38.50.02.002 • Newspaper: 00590 09Aug17 SP22\_324.28.38.50.02.002 (MN) • Language: English • Issue: 09/08/2017 • Doc size: 297 x 210 mm • Calitho #: 08-17-123679 • AOS #: OME\_00590 • EB 08/08/2017

ХААН банк	Хуудалгаа хөгжлийн банк			
	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2437.00	2451.00	ФУНТ	3111.00
ЕВРО	2837.00	2903.00	РУБЛЬ	39.90
ИЕН	22.00	22.40	ЮАНЬ	364.00

Хуудалгаа хөгжлийн банк	Хуудалгаа хөгжлийн банк			
	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2435.00	2451.00	ФУНТ	3125.00
ЕВРО	2849.00	2912.00	РУБЛЬ	39.86
ИЕН	21.86	22.47	ЮАНЬ	363.00

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

## УЛС ТӨР

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ



# Д.ДОЛЖИНСҮРЭН: Ипотекийн найман хувийн зээлийг 2018 онд яаж шийдэх нь сонирхол татаж байна

Түүнээс биш Монголбанкнаас ипотекийн найман хувийн зээлийг зогсоосон зүйл байхгүй байх.

**-Ер нь энэ зах зээлийн цаашдын чиг хандлагыг та яаж харж байна вэ. Магадгүй найман хувийн ипотекийн зээлээс өөр хувилбар байж болох юм биш үү?**

-Хоёр жилийн өмнө ганцхан найман хувийн зээл л байлаа. Одоо бол найман хувийн зээлийн эх үүсвэр хязгаарлагдмал болсонтой холбоотойгоор арилжааны банкууд түрүүчээсээ бага хүүтэй зээлийн бүтээгдэхүүнийг санал болгож байна. Барилгын компаниуд ч зөвхөн банкны зээлийг хүлээгээд суулгүй өөрсдийнхөө борлуулалтын арга хэрэгслийг илүү уян хатан болгож, барилгын компани, банк бус санхүүгийн байгууллага нийлж зээлийн хувилбар гаргах зэргээр тал талаасаа харин ч их хичээж байгаа. Нэг үеэ бодвол энэ зах зээл илүү тодорхой болж эхэлж байна. Зээлийн үлдэгдэл 4.2 их наяд төгрөг болчихсон. Зээл авсан иргэдийн тоо 92 мянгад хүрлээ. Ингэхээр макро төвшинөө харж энэ зах зээл дээр зохицуулалт хийхгүй бол бас болохгүй. Энгийн иргэдийн нүдээр буюу микро төвшиндөө найман хувийн зээлийг зогсолтгүй олгосоор байх нь сайн, борлуулалт жаахан ч гэсэн өснө гэж хардаг. Гэвч эдийн засгийн макро төвшиндөө тодорхой хэмжээний хүндрэлүүд гарч ирж, зохицуулалт хэрэгтэй болсон.

**-Юутай ч орон сууцны үнийн индекс сүүлийн хоёр жил дараалан буурч байгаа нь иргэдийн хувьд сайн мэдээ. Одоо ч гэсэн өмнө сарынхаас 0.7, өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.2 хувиар буурчигдсан байна. Дээрээс**

**нь санаагаар болдог бол найман хувийн ипотекийн зээлээ шуурхайхан шиг авахыг хүсч байгаа даа?**

-Төрсгасгаас барьж буй бодлого энэ зах зээлд их нөлөөтэй. Эрх баригчдын нэг үг, нэг өгүүлбэр их чухал. Ипотекийн зээлийн журмын нэг үг, нэг өгүүлбэр өөрчлөгдөхөд л энэ салбарт асар их өөрчлөлт болно. Өөрөөр хэлбэл, дэвэр эрэлт, нийлүүлэлтийн хуулиараа явдаг салбар бас биш. Барилгын салбарын маш том хөдөлгөгч хүч нь ипотекийн зээл. Тийм учраас энэ зээлийг 2018 онд яаж шийдэх вэ гэдэг нь хамгийн сонирхолтой асуудал болчихоод байгаа юм. Яг одоогийнхоороо буюу 2017 оны нөхцөл байдлыг ирэх жил үргэлжлүүлээд явбал барилгын салбарт мөн л адилхан хүндрэлийг авчирна. Орон сууцны борлуулалт удааширна. Үнийн хувьд барилгын компаниуд арай алдагдалд орчихгүйхэн шиг барьж байгаа. Гэхдээ энэ нь хэдий болтол үргэлжлэх вэ.

**-Одоо зах зээлд хэчнээн орон сууц нийлүүлж, хэдийг нь борлуулаад байна вэ?**

-Орон сууц, хаус нийлээд 480 төслийн 85 мянган байр одоо зах зээлд байна. 30 хувь нь захналга аваад борлуулагдчихсан байгаа. Борлуулалтын явцыг ажиглахад энэ ондоо багтаж зарагдахгүй. Ирэх онд ч борлуулалт үргэлжилнэ. Гэтэл дараагийн орон сууцны нийлүүлэлт хийгдсээр байх нь ойлгомжтой. Барилгын компаниуд эрэлтгүй гээд бүх ажлаа арай зогсоочихоогүй. Дараагийн ажлуудаа гүйцэтгэж эхлээд байна. Гэхдээ өмнө нь барьсан байраа биш арай жаахан өөр хувилбарыг санал болгож байгаа. Барилгын салбар өчнөөн мянган ажиллах хүчийг шингээдэг. Тэр болгон цомхотгол хийгээд байж болохгүй шүү дээ.

Г.ГАНЧИМЭГ

Сүүлийн хоёр жилийн хугацаанд орон сууцны үнэ буурсаар байна. Энэ нь орон сууц авах гэж буй хэрэглэгчдэд таатай нөхцөл болж байгаа ч барилгын олон компанид сул зогсолт, орон тооны цомхотгол авчирсан юм. Тиймээс цаашид энэ зах зээл иймэрхүү байдлаар удаан явахгүй гэдэг нь тодорхой боллоо гэж орон сууцны үнийн индексийн судалгааг сүүлийн гурван жил гаруйн хугацаанд хийж буй "Тэнхлэг зууч" компанийн гүйцэтгэх захирал Д.Должинсүрэн ярьж байна. Ингээд түүнтэй ярилцсанаа хүргэе

**-Орон сууцны үнэ сүүлийн хоёр жил дараалан буурчээ. Гэхдээ борлуулалт өсөөгүй гэдэг нь статистик мэдээлээс харагдаж байна. Гэтэл хэрэглэгчдийн олонхи нь ипотекийн зээлийг зогсоочихлоо гэдэг гомдол гаргадаг. Харин банкууд болохоор орон сууцны зээлийг хязгаартайгаар өгч байгаа гэдэг л дээ. Ер нь энэ зах зээл дээр юу болоод байгаа юм бэ?**

-Ипотекийн зээлийн санхүүжилт тодорхой байгаа л даа. Монголбанкнаас сар бүр зээлийн эргэн төлөлтөөр 20 гаруй тэрбум төгрөг оруулж байна. Гэхдээ зээлийн хүүгийн эргэн төлөлтийг оруулахгүй байх шиг байгаа юм. Яг зээлийн өөрийнх нь эргэн төлөлтийг бол оруулж байгаа. Улсын төсвөөс 111 тэрбум төгрөг орохоор байсан. Энэхүү санхүүжилт нь энэ сард ороод бараг дуусч байна. Цаашид сар бүр олгодог байсан ипотекийн зээлийн санхүүжилт зогсох нь тодорхой болж байна. Тиймээс ипотекийн зээлийн санхүүжилт өсч, улмаар эрэлт нэмэгдэж, орон сууцны үнэ өсөөд борлуулалт нэмэгдэнэ

гэдэг хүлээлт байх боломжгүй. Харин ирэх онд ямар гаргалгаа байх бол гэдэг нь сонирхолтой. Гэхдээ 2017 оных шиг зээлийн эргэн төлөлтөөр явбал хүндрэлтэй гэдэг нь тодорхой болсон. Барилгын салбарт бизнес эрхэлж буй хүмүүс ч энэ онд ямар нэгэн өөрчлөлтийг хүлээгээд хэрэггүй гэдгийг ойлгож байгаа. Харин 2018 онд яах вэ гэдэг гарцыг хайж байна.

**-Одоо амралт зугаалтын улирал дуусч байна. Удахгүй хичээлийн шинэ жил эхэлнэ. Тиймээс улирлын нөхцөл байдалтай холбоотойгоор орон сууцны үнэ буурч байгаа хэдий ч түрээсийн байрны үнэ өсдөг байж магадгүй?**

-Намар түрээсийн байрны үнэ нэмэгддэг. Орон сууцны борлуулалт ч тодорхой хэмжээгээр өсдөг л дөө. Гэхдээ одоохондоо мэдэгдсэн юм алга. Харин наймдугаар сарын сүүлч, есдүгээр сард орон сууц, түрээсийн байрны үнэ аль аль нь жаахан нэмэгдэх болов уу.

**-Ядах нь ээ, ипотекийн найман хувийн зээлийг зогсоочихсон байдаг. Намар болохоор хүссэн, хүсээгүй**

**орон сууц, түрээсийн байрны үнэ өсөх нь. Магадгүй бага зэргийн өсөлт байх хэдий ч ядарсан иргэдийн нуруун дээр буухдаа том дарамт болох нь ойлгомжтой?**

-Зээлийн санхүүжилтийн эх үүсвэр маш хязгаарлагдмал болсон. Өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад бараг тав дахин буурлаа. Одоо сард 20-30 тэрбум төгрөг орж чадаж байвал их юм. Гэхдээ ипотекийн зээлийн эх үүсвэр хязгаарлагдмал болсон ч эрэлт буураагүй. Орон сууцны зээлийн хүсэлт банкуудад хуримтлагдчихсан байна. Тиймээс одоо нэмж зээлийн хүсэлт авахаасаа илүү өмнө хуримтлагдчихсан байгаа хүсэлтийг яаж шийдвэрлэх вэ гэдэг нь асуудал болж байгаа юм. Үүн дээр Монголбанк ч, арилжааны банкууд ч толгойгоо гашиглаж байх шиг байна. Өчнөөн мянгаараа зээлийн хүсэлтгирээд хуримтлагдчихсан, түүнийг шийдэж чадаагүй байж дараачийн буюу шинэ зээлийн хүсэлт авах нь хэцүү. Ипотекийн найман хувийн зээл дээр боломжгүй учраас банк өөрийн эх үүсвэрээс зарим зээлийг гаргаж байгаа.

**МОНГОЛЫН МЭДЭЭ**

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ**  
99189158

Хариуцагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ**  
90873012

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ**  
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД**  
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ**  
88006842

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН**  
96017873

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ**  
99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ**  
99173710

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ**  
99042510

**Э.САЙНЗАЯА**  
99197866

Дугаарыг эрхэлсэн **Э.ЭНХЦЭЦЭГ**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528  
Индекс: 100757

**Редакцийн хаяг:**  
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.  
2 давхар. 209, 211 тоот

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

## Хууль зүйн яам ӨМӨЗО-оос туршлага судлав

Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт БНХАУ-ын ӨМӨЗО-ны Засаг захиргааны дэд тэргүүлэгч, Нийгмийн аюулаас хамгаалах тэнхимийн дарга Ма Мин тэргүүтэй төлөөлөгчдийг өчигдөр хүлээн авч уулзжээ. Уулзалтаар хар тамхи, хил дамнасан, цахим, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлд цаашид хамтран ажиллах сонирхолтой байгаагаа ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт илэрхийллээ. Тэр дундаа ӨМӨЗО хяналтын камерын системийг ашиглаж гэмт хэргийн гаралт, тоог бууруулсан сайн жишгийг Монгол Улсад нутагшуулах сонирхолтой байгаагаа С.Бямбацогт сайд онцлон тэмдэглэв. ӨМӨЗО-ны Хөх хот нь гурван сая хүн амтай бөгөөд гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх хяналтын камерын системийг суурилуулснаар гэмт хэрэг, зөрчил 30 хувиар буурч, илрүүлэлт 17 хувиар өссөн байна. Түүнчлэн энэхүү камерын хяналын системийг ажиллуулж эхэлснээс хойш 200 хоногийн хугацаанд ӨМӨЗО-ны цагдаагийн байгууллагад нэг ч гэмт хэрэг, зөрчлийн дуудлага ирээгүйг Нийгмийн аюулаас хамгаалах тэнхимийн дарга Ма Мин онцолсон байна. Өөрөөр хэлбэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд орчин үеийн техник, технологийн шийдийг ашиглах нь "гар нүцгэн" тэмцэхээс хувь илүү үр дүнтэй ч төлөөлөгчид дурьдсан юм.



## МАН-ын мөнгөтэй гарууг "халиарчиг"-гаа гөвшүүлэх нь

УИХ-ын сонгуулийн үеэс эхэлсэн төрийн албыг наймаалцах, худалдаж авах тухай өгүүлэх 60 тэрбумыг тойрсон хэрэг эдүгээг хүртэл үргэлжилсээр байна. Тэгвэл "Цэнзүргүй сурвалжлага" нэвтрүүлгээр дахин 40 минутын бичлэгийн нийтэд ил болгосон нь эдүгээ шуугиан тарьж байна. Уг бичлэг ил болсноос хойш "халиарууд" гэх үг "моданд" орж байгаа гээд хэлчихэд ч хэтийдэхгүй. Тодруулбал,

МАН-ынхан мөнгө төлж албан тушаал аваагүй хүмүүсээ "халиарууд" хэмээн нэрлэдэг гэнэ. "халиарууд" гэх нэршилээс болж МАН-ын гишүүд дотроо ёстой л бужигнаж байгаа бололтой. Ямар сайндаа л УИХ-ын гишүүн Л.Оюун-Эрдэнэ өөрийн твиттер хуудастаа "60 тэрбумтнууд биднийг "халиарчид" гэж нэрлэдэг аж. Энэ нь мөнгө өгдөггүй гарууд гэсэн утгатай гэнэ.



Ардын намд халиарчдын хувьсгал тун удахгүй хэмээн жиргэжээ. Ямартай ч, тус намын мөнгөтэй гишүүд "халиарчид"-ынхаа гарт өртөж, нэлээд сайн гөвшүүлэх бололтой дог.

## ХХААХУ-ийн дэд сайд Ж.Сауле Турк улсын Гааль, худалдааны дэд сайдыг хүлээн авч уулзав

ХХААХУ-ийн Дэд сайд Ж.Сауле Бүгд Найрамдах Турк улсын Гааль, худалдааны дэд сайд Фатих Чифчи, Элчин сайд Ахмет Язал, Гааль худалдааны яамны Европын Холбоо болон Гадаад хамтын ажиллагааны газрын дарга Хасан Косеоглу тэргүүтэй хүмүүсийг хүлээн авч, уулзсан байна. Уулзалтын эхэнд ХХААХУ-ийн Дэд сайд Ж.Сауле хоёр орны хамтын ажиллагааны талаар, яамны бодлого, авч хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өглөө. Тэрээр "Монгол Улсын Засгийн газар 2016 онд шинээр эмхлэгдэн зохион байгуулагдсан бөгөөд Хүнс, хөдөө

аж ахуйн яам маань Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болж үндсэн чиг үүрэгт нь хөнгөн үйлдвэр, жижиг дунд үйлдвэрийн салбар нэмэгдсэн. Үндэсний хэмжээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт Засгийн газраас "Эрүүл хүнс, эрүүл монгол хүн" гэсэн уриан доор "Мах сүүний анхдугаар аян", "Монгол мал" хөтөлбөр, "Үйлдвэржилт 21:100" зэрэг томоохон хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна" гэдгийг онцлов. Мөн Монгол Улс нь мах, махан бүтээгдэхүүний эргэлтийн хэмжээг нэмэгдүүлэх, Жижиг дунд үйлдвэрлэл,

тэр дундаа малын гаралтай түүхий эд боловсруулах чиглэлээр хамтран ажиллах талаар санал хүргүүлээ. Бүгд Найрамдах Турк улсын Гааль, Худалдааны Дэд сайд Фатих Чифчи "Манай хоёр улс олон жилийн турш найрсаг харилцаатай байж ирсэн. 2012 онд хоёр улсын худалдааны эргэлт 50 сая байсан бол 2013 онд 30 сая болж буурсан. 2013 онд манай улсын Ерөнхий сайд Монгол Улсад айлчлах үеэр хоёр улсын худалдааны эргэлтийг 205 сая ам доллар хүргэх зорилт тавьсан. Энэ зорилтод одоогоор хүрч чадаагүй ч хүрч чадна гэдэгт итгэлтэй байна" гэв.

# ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр

# МАН ХЭЗЭЭ МӨДГҮИ ДЭЛБЭРЭХ НЬ

“Ажилдаа ирж байна уу, зүүн эргэж чадахгүй л явна”

**Үргэлжлэл.**  
**Түрүүч нь I нүүрт**

Энэ мэт улсаа биш амин хувна бодсон нэг хэсэг хүний үйлдлээс болоод МАН муу нэр зүүчихлээ. Муу нэр гэж хамгийн дээд зэргээр зөөлрүүлж хэлээд байна. Одоо тэр зүүсэн муу нэрээ хусаж эхэлсэн нь дээр юм биш үү. Хусаад хусаад арилахгүй л байх. Гэхдээ ядаж бүдгэрнэ шүү дээ. Нэн түрүүнд 60 тэрбум төгрөгийн асуудалтай холбоотой хэргийг нэг тийш нь болго. Эхлээд энэ байж боломгүй

...Гэхдээ дэлбэрэх ёстой бол нэг дэлбэрчих л хэрэгтэй. Бүх муугаа шатаагаад, хусаад хаячихмаар байна. Цэвэрхэн нэрийг шороотой хутгаад байгаа нөхдийг гэвж хаячихаад нэг урагшилж, шинэчлэгдэх цаг болсон юм биш үү. Тэгэхгүй бол 60 тэрбум, бандааштайгаа зууралдсаар 2020 онд “халагдах”-аас өөр сонголт үлдэхгүй л болов уу...

хэргийг санаачилсан, төрийн албыг захдээр наймаа хийхээс амархан гэж сэтгэсэн, зүтгэсэн хүмүүст хариуцлага тооцох хэрэгтэй. Энэ бол нэг намыг муухай харагдуулахаасаа гадна төрийн албыг хууль бусаар авах гэж оролдсон гэмт хэрэг. Оролдсон гэдгээс цаашлаад авсан гэмт хэрэг ч гэж хэлж болохоор болчихоод байна. Хуулийнхан л жаахан алгуур ажиллаад байгаа болохоос хэрэг бол нотлогдогоо нотлогдчихлоо. Тэгэхээр хууль хяналтынхан нэг талд нь гаргах байх. МАН ч гэсэн нэрээ цэвэрлэх үүднээс 1-2 хүнд хариуцлага тооцох болов уу. Эвлүүлж гэж гүрийгээд одоо амжилт олохгүй. Тийм болохоор эвтэйхэн шийдэх арга олоод, хэдэн хүнээр “туг тахиx”-аас өөр аргагүй. Гэхдээ жаахан томхон “загас”

л дэгээдээсэй гэж найдаа. Зүгээр нэг “жараахай” гаргаж шидчихээд, нам цэвэршчихлээ гээд өнгөрөхгүй байвал сайнсан. Шадар сайдын асуудалд ч гэсэн ард түмэн хариулт нэхэж байгаа. Мэдээж нам дотор асуудал өрнөж байгаа. Тэр асуудлын галыг өрдөж өгч байгаа хүчилтөрөгч нь 60 тэрбум, Шадар сайдын асуудал. Тийм болохоор бас нэг, хоёр хүнд хариуцлага тооцож, ядаж л албан тушаалаас нь огцруулах шаардлагатай. Тэгж байж өнөө муу нэр чинь бага ч болов хусагдаж, бүдгэрэх байх. Ерөөсөө энэ намд яаралтай хусаж муу нэр олон байна. Хамгийн залуу тодотголтой гишүүн нь хүртэл хэрэгт орооцолдоод, одоо болтол намынхаа нэр хүндийг шавартай хутгаад л явж байгаа. Хэчнээн гүтгэсэн гэж зүтгэж байгаа ч өөрөө ам алдчихсан болохоор одоо түүнд итгэх хүн гэж алга. Тиймээс бас хариуцлага тооцож, хусах муу нэртнүүдийнхээ жагсаалтад багтаасан нь дээр болов уу. МАН бол Монголын улс төрд байгаа том хүчний нэг. Энэ намд Монголоо хөгжүүлж, өөд нь татъя, ард иргэдээ сайн сайхан амьралд хөтөлжэе гэсэн бодолтой шилдэг сэхээтэн, улстөрчид бий. Тэд энэ бүхнээс ичиг байгаа байх. Тэгээд ч мөнхийн юм гэж байхгүй. Гуравхан жилийн дараа сонгууль болно. Ард түмэн дүнгээ тавина. Сая Ерөнхийлөгчийн сонгуулиар л дүнгээ тавьчихсан даа, бараг. МАХН-аас өрсөлдсөн С.Ганбаатар хэчнээн хүний

санал авч, ямар хэмжээнд өрсөлдлөө. Ард түмэн ингэж л дүн тавьж байна. Тийм болохоор МАН-ынхан алдаа, завхралаа даруйхан засах цаг болж. Өөрчлөлт, шинэчлэлт хийх хэрэгтэй. Тэгэхдээ өөрчлөлт хийхдээ өнөөдөр зүгээр ажлаа хийж байгаа Засгийн газраа оролдох биш өөр хүмүүст хатуухан хариуцлага тооцох хэрэгтэй. 2016 оны сонгуулиар ард түмэн эв нэгдэлтэй нам гэж харж л сонголт хийсэн. АН-ынхан дотроо хэтэрхий их толхилцоод байна.

Нөгөөх нь тэгдэггүй, эвтэй, найртай гэж сонголт хийсэн. Гэтэл өнөө сайхан эв нэгдэл нь худлаа байж гэдэг нь одоо харагдаад эхэллээ. Тийм болохоор нэг талдаа гарах цаг болсон. Ерөнхийлөгчийн сонгуульд ялагдал хүлээхэд хэн муу ажиллав. Түүндээ л хариуцлага тооцох хэрэгтэй байх. Ядаж л пиар сурталчилгааг хариуцсан, штаб ахлаж ажилласан хүмүүстээ хариуцлага тооцож, албан тушаалаас нь буулгах хэрэгтэй биз дээ. Энэ бүх шалтга МАН-ыг хэтэрхий халааж, дэлбэлэх нь. Гэхдээ дэлбэрэх ёстой бол нэг дэлбэрчих л хэрэгтэй. Бүх муугаа шатаагаад, хусаад хаячихмаар байна. Цэвэрхэн нэрийг шороотой хутгаад байгаа нөхдийг гэвж хаячихаад нэг урагшилж, шинэчлэгдэх цаг болсон юм биш үү. Тэгэхгүй бол 60 тэрбум, бандааштайгаа зууралдсаар 2020 онд “халагдах”-аас өөр сонголт үлдэхгүй л болов уу.

**Үргэлжлэл.**  
**Түрүүч нь I нүүрт**

Гэтэл очигдөр энэ чиглэлд автобус үйлчлэхээ больсон төдийгүй зүүн тийш эргэхийн тулд Улиастай, Дунжингарав-Шаргаморьтын автобус дамжиж явсаар бага үдтэй уралдан сая нэг юм ажилдаа ирлээ. Ингэж хэлэхээр зарим хүн таксидахгүй ясан юм гэх байх. Өдөр бүр таксидаж чадахгүй болохоор яалтай билээ. Таксидлаа гэхэд зүүн эргэх боломж хайн үхэр шиг чингээрээ явсаар баруун дөрвөн зам орж таарах байх. Мөнгө ч урсана. Тиймээс Хан –Уул дүүргээс шулуун яваад 100 айл хүрэх автобусны маршрут бий болгож өгөөч хэмээн нийслэлийнхнээс хүсэх байна. Ер нь зүүн дөрвөн замаас баруун дөрвөн зам хүртэлх зам бол Улаанбаатар хотын ачаалал бага үүрдэг хэсэг. Автобусууд нэгдүгээр эгнээгээр зорчдог тул тэр бүр түгжирч гацаад байдаггүй. Нөгөөтэйгүүр, төв замаас зүүн эргэдэг хэдхэн газар бий. Цэцэг төв, Сүхбаатарын талбай, Багшийн дээд, Бөхийн өргөө ингээд л болно. Эднээс хамгийн их ачаалал үүрдэг нь Цэцэг төв, Багшийн дээд, Бөхийн өргөө. Эл урсгалыг хааснаар төв замын ачаалал буурна гэдэг юу л бол. Харин ч цагийн цагт таг гацчихсан байдаг зүүн дөрвөн замаас “Бөмбөгөр” худалдааны төв чиглэл, Дунжингараваас Сансар чиглэлийн зам ачааллаа даахгүйд хүрэх бус уу. Э.Бат-Үүл дарга өнгөрсөн дөрвөн жилд Улаанбаатар хотын төв зам дагуух ачааллыг багасгах үүднээс хэдэн газарт уулзвар, гэрлэн дохиног шинээр бий болгосноор асуудал ерөнхийдөө шийдэгдсэн гэж дүгнэж болно. Үнэн хэрэгтээ улаанбаатарчуудад энэ асуудлыг шийдэх цорын ганц зам буй. Тэр нь давхар зам эс бөгөөс метроны шугам тавих асуудал билээ. Олон ч жил ярьж байгаа. Түүнээс зүүн, баруун тийш эргэх асуудлыг мухардалд оруулснаар замын ачаалал багасна гэдэг юу л бол. Хэдхэн хоноод хичээлийн шинэ жил эхэлнэ. Жирийн үедээ ачааллаа даахгүйд хүрдэг автозам маань хүүхэд багачуудын хичээл жигдэртэл юу болох нь ойлгомжтой. Аягүй л зүүн тийш эргэх гэж мунгинаж явсаар их урсгалд хөвөн баруун эргээд гэртээ ирсэн байх вий дээ. Швед улсын туршлага юм гэнэ лээ. Авто замынхаа урсгал, ачааллыг нэгэн зууны өмнө шийдэж, хотынхоо хөгжлийг түүндээ уялдуулж хөгжсон улсын амьдралаар хот төлөвлөлтгүй явж ирсэн мань мэт амьдрах гэж зүтгэхийн хэрэг байгаа ч юм уу, хэн мэдлээ. Түүний оронд байгаа нөхцөл байдал дээрээ асуудлыг шийдэх гарц хайсан дээр санагдана. Тухайлбал, дугаарын хязгаарлалтыг нэг бус хоёр өдөрт хамруулбал яасан юм. Долоо хоногт нэг өдөр улсын унаандаа сууж болоод байгаа ард түмэн хоёр өдөр автобусаар зорчин, алдагдалд ороод байгаа автобус баазуудыг авраад зогсохгүй агаарын бохирдлыг багасгахад тэр хэрээр нэмэр болох нь мэдээж. Тэгэхгүй бол зөвхөн баруун эргэн гэр рүүгээ буцаад явчих гээд хэцүү байна, хотын удирдлагууд аа. Мөн туршлага бүхэн амьдрал дээр биеллээ олж, амжилт дагуулдаггүйг Монгол Улсад хэрэгжүүлсэн мөн ч олон туршлага харуулсан даа. Туршлага судлах гээд явах бүрийд улсын төсвийн хэдэн төгрөг хэдэн арван саяараа урсах нь бий. Ганц хүн яваад судалчихдаг туршлага гэж байдаггүй. Швед хүрэх нэг хүний онгоцны тийз ирэх очихтойгоо нийлэн 2.5 сая. Арван хүнтэй ажлын хэсэг явсан байлаа гэхэд 25 сая. Дээр нь зочид буудал, хоолны зардал гэж бий. Ингээд бодохоор хүн ам цөөн жижиг сумын төсвөөр зүүн тийш эргүүлэхгүй байх туршлагыг судлаад иржээ. Үүнээс гадна амьдралд нийцэхгүй нь гээд хүчингүй болбол яана. Маргаашаас маш олон жолооч дүрмийн алдаа гарган, олоогоо хасуулж, торгуулах нь дамжиггүй. Хөдөө гадаа гэлтгүй, зурагт үзэж мэдээлэл аваагүй жолооч нар зүүн эргэх гэж байгаад баларна. Тэр бүхнийг бидний алдаа гээд торгуулийн нь нөхөн олгохгүй нь лавтай. Энэ мэтчилэн зүүн тийш эргэхийг өөр өнцгөөс, ард түмний нүдээр харвал асуудал их байна шүү, нөхөд өө.

## НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААНЫ ЗАР

“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 240 дугаар тогтоолоор Хьюндай Верна маркын автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахаар шийдвэрлэв.

### 1. Дуудлагаар худалдах хөрөнгийн танилцуулга

д/д	Автомашины марк	Улсын дугаар	Үйлдвэрлэсэн он/ашиглалтад орсон он	Худалдах доод үнэ	Дэнчингийн хэмжээ
1	Хьюндай Верна (Hyundai Verna)	07-69 УНУ	2002/2008	1,500,000	375,000

### 2. Дуудлагын худалдааны ерөнхий мэдээлэл:

Дуудлагын худалдаа болох хугацаа	2017 оны 08 дугаар сар 22-ны 11:00 цаг
Дуудлага худалдаа болох газар	“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын төв байр
Худалдах доод үнэ	1,500,000 төгрөг
Дэнчингийн хэмжээ	375,000 төгрөг
Худалдах, худалдан авах гэрээний ерөнхий нөхцөл	Худалдан авагч нь дуудлага худалдаагаар худалдан авсан эд хөрөнгийн үнийг 14 хоногийн дотор төлнө.
Дэнчинг байршуулах данс	Хүлээн авагч байгууллага: “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ Банкны нэр: Төрийн банк Дансны дугаар: 340004009911

### 3. Дуудлагын худалдаанд хүсэлт ирүүлэх

Дуудлагын худалдаанд оролцох хүсэлтийг 2017 оны 08 дугаар сар 22-ны 11:00 цаг хүртэл Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, Тээвэрчдийн гудамж, Зам, тээврийн хөгжлийн яамны өргөтгөл, Автотээврийн үндэсний төв, 1-р давхар, 108 тоот өрөөнд хүлээн авна. Хугацаа хоцорсон хүсэлтийг хүлээн авах боломжгүйг анхаарна уу.

### 4. Худалдах хөрөнгийн талаар мэдээлэл авах

Дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийг үзэж болох бөгөөд холбогдох мэдээллийг 99101763 дугаарын утсаар авч болно.

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Тендер шалгаруулалтын нэр: **Шалгалт тохируулгын лабораторийн багаж хэрэгсэл нийлүүлэх.**

Тендер шалгаруулалтын дугаар: **АТУТ-17/020**

**Автотээврийн үндэсний төв ТӨҮГ** нь эрх бүхий тендерт оролцогчдоос **Шалгалт тохируулгын лабораторийн багаж хэрэгсэл нийлүүлэх тухай битүүмжилсэн** тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50,000 төгрөгөөр, Төрийн банкны 340004009911 тоот дансанд тушааж, худалдан авна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Санал болгож буй үнийн дүнгийн 50%-иас дээш байх**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн хэмжээ: **Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувьтай тэнцэх**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 3 жил**

Тендерийн хамт 1,000,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 11 цаг 30 минутаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 12 цаг 00 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй

Дотоодын давуу эрх тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, Тээвэрчдийн гудамж, Зам, тээврийн хөгжлийн яамны өргөтгөл, 1-р давхар, 108 тоот Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн Г.Чинзориг. Утас: 99101763**

## Тендерийн урилга

Огноо: **2017-08-10** Материал хүлээж авах сүүлийн хугацаа: **2017-09-11**

Тендер шалгаруулалтын нэр: **Архангай, Булган, Өвөрхангай аймгуудын нутгийн зааг “Элсэн тасархай”-д аймаг дундын Замын хяналтын төвийн агаарын шугамын холболт**

Тендер шалгаруулалтын дугаар: **АТУТ 17/026**

“Автотээврийн үндэний төв” эрх бүхий тендерт оролцогчдоос **Архангай, Булган, Өвөрхангай аймгуудын нутгийн зааг “Элсэн тасархай”-д аймаг дундын Замын хяналтын төвийн агаарын шугамын холболт**-ыг гүйцэтгэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 50000 төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

- Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил буюу**

**2015, 2016 онуудын борлуулалтын орлого өссөн дүнгээр аль нэг жилд 140 сая төгрөгнөөс багагүй байна.**

- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн хэмжээ: Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн нийт дүн: **Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.**
- Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо.
- Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 онуудын аль нэг жилд ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа бие даан гүйцэтгэсэн байна.**
- Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:

Барилга, хот байгуулалтын яамны 2.2.2. Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, Холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам

сүлжээний угсралт /хуучнаар бол 2.2.2, 2.2.4, 2.2.9/ Эрчим хүчний яамны: 3.2.3. Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар /0.4-10кВ/. Тухайн ажлын шаардлагыг хангахуйц Барилга, хот байгуулалтын яамны тусгай зөвшөөрөлтэй байж болно /дүйцүүлнэ/.

Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн 2 хувиар тооцож тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 09-р сарын 11 -ний өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 09-р сарын 11 -ний өдрийн 10 цаг 30 минутад** нээнэ.

Гадаадын этгээд оролцохгүй

Дотоодын давуу эрх тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

*Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Тээвэрчдийн гудамж, Өөрийн байр, 2-р давхар, 207 тоот*

*Худалдан авалт хариуцсан ахлах мэргэжилтэн Ж.Банзрагч, 88280448*

## МЭДЭЭЛЭЛ

## АЛБАДАН ДУУДЛАГА ХУДАЛДАА

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас дараах үл хөдлөх эд хөрөнгө, орон сууц, барилга байгууламжийн АНХНЫ албадан дуудлага худалдааг 2017 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 10 цагт албаны байранд зохион байгуулна. Оролцогчдыг 2017 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 14.00 - 17.00 цагийн хооронд Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны нэг цэгийн өрөөнд

бүртгэнэ. Хугацаа хоцорсон хүсэлтийн хүлээн авах боломжгүйг анхаарна уу.

Бүртгүүлэхээр ирэхдээ дуудлага худалдааны дэнчингийн мөнгийг Улаанбаатар банкны 2617001560 тоот дансанд тушааж нэг хувийг авчирна уу. Хаяг: Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, Үндсэн хуулийн гудамж-3, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас дараах үл хөдлөх эд хөрөнгө, орон сууц, барилга байгууламжийн 2 ДАХЬ албадан дуудлага худалдааг 2017 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 10 цагт албаны байранд зохион байгуулна. Оролцогчдыг 2017 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 14.00 - 17.00 цагийн хооронд Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны нэг цэгийн өрөөнд

бүртгэнэ. Хугацаа хоцорсон хүсэлтийн хүлээн авах боломжгүйг анхаарна уу.

Бүртгүүлэхээр ирэхдээ дуудлага худалдааны дэнчингийн мөнгийг Улаанбаатар банкны 2617001560 тоот дансанд тушааж нэг хувийг авчирна уу. Хаяг: Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, Үндсэн хуулийн гудамж-3, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба

ЦАХИМ ХАЯГ: <http://www.nshga.cd.gov.mn>,  
[www.facebook.com/pages/Нийслэлийн-Шийдвэр-Гүйцэтгэх-Алба](http://www.facebook.com/pages/Нийслэлийн-Шийдвэр-Гүйцэтгэх-Алба)

ЦАХИМ ХАЯГ: <http://www.nshga.cd.gov.mn>,  
[www.facebook.com/pages/Нийслэлийн-Шийдвэр-Гүйцэтгэх-Алба](http://www.facebook.com/pages/Нийслэлийн-Шийдвэр-Гүйцэтгэх-Алба)

№	Үл хөдлөх эд хөрөнгийн хаяг байршил	Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.1-д заасан санал болгох доод үнийг тохиролцсон болон үнэлгээчний тогтоосон зах зээлийн үнийн 70 хувь	Хариуцсан шийдвэр гүйцэтгэгч, утасны дугаар
<b>НЭГ. ОРОН СУУЦ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖ</b>			
1	Хан-Уул дүүргийн 11-р хороо Дунжингарав гудамж 25 байр 1 тоот 240 м.кв талбайтай 2 өрөө амрагчийн сууцны зориулалттай 98 хувийн гүйцэтгэлтэй үл хөдлөх	470,400,000	Д.Долгорлхам 89086140
2	Хан-Уул дүүргийн 1-р хороо 120 мянгат хороолол 5-р байр 26 тоот 28 м.кв талбайтай 2 өрөө орон сууц	39,340,000	С.Самьяа 89086138
3	Баянгол дүүрэг 9-р хороо, 3-р хороолол /16093/ Хасбаатарын гудамжны 25-р байрны 38 тоот 44 м.кв талбайтай 2 өрөө орон сууц	63,140,000	А.Осорбурам 89086176
4	Баянзүрх дүүргийн 25-р хороо 13-р хороолол Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж 66 байр 5 тоот 89,9 м.кв талбайтай 3 өрөө орон сууц	110,600,000	А.Солонго 89086188
5	Хан-Уул дүүргийн 13-р хороо Шувуун фабрик /17170/ Шувуун фабрикийн зам 45 тоот үйлдвэр агуулахын зориулалттай 864 м.кв талбайтай үл хөдлөх, Хан-Уул дүүргийн 13-р хороо Шувуун фабрик /17170/ Шувуун фабрикийн зам 45/1 тоот үйлдвэрийн зориулалттай 720 м.кв талбайтай үл хөдлөх 4181 м.кв газрын хамт	1,673,000,000	А.Солонго 89086188
6	Баянгол дүүргийн 2-р хороо Энхтайваны өргөн чөлөө 55-р байр 35 тоот 51,5 м.кв талбайтай 2 өрөө орон сууц	133,000,000	А.Солонго 89086188
7	Баянзүрх дүүргийн 8-р хороо "Баянзүрх" хотхон 110 дугаар байрны 68 тоот 43 м.кв талбайтай орон сууц	45,500,000	Т.Ариунболор 89086187
8	Баянзүрх дүүрэг 7-р хороо 23 байр 31 тоот 27 м.кв талбайтай 2 өрөө орон сууц	49,000,000	Т.Ариунболор 89086187
9	Хан-Уул дүүргийн 4-р хороо Нүхтийн ам /17090/, 26/8 тоот 145,28 м.кв талбайтай, аялал жуулчлалын зориулалттай 30 хувийн гүйцэтгэлтэй дуусаагүй барилга	193,537,680	Ч.Оюунбилэг 89086154
10	Хан-Уул дүүргийн 4-р хороо Нүхтийн ам /17090/, 26/3 тоот 144,81 м.кв талбайтай, аялал жуулчлалын зориулалттай 30 хувийн гүйцэтгэлтэй дуусаагүй барилга	192,911,530	Ч.Оюунбилэг 89086154
11	Хан-Уул дүүргийн 4-р хороо Нүхтийн ам /17090/, 26/4 тоот 144,81 м.кв талбайтай, аялал жуулчлалын зориулалттай 30 хувийн гүйцэтгэлтэй дуусаагүй барилга	192,911,530	Ч.Оюунбилэг 89086154
12	Хан-Уул дүүргийн 4-р хороо Нүхтийн ам /17090/, 26/5 тоот 144,81 м.кв талбайтай, аялал жуулчлалын зориулалттай 30 хувийн гүйцэтгэлтэй дуусаагүй барилга	192,911,530	Ч.Оюунбилэг 89086154
13	Хан-Уул дүүргийн 4-р хороо Нүхтийн ам /17090/, 26/7 тоот 145,28 м.кв талбайтай, аялал жуулчлалын зориулалттай 30 хувийн гүйцэтгэлтэй дуусаагүй барилга	193,537,680	Ч.Оюунбилэг 89086154
14	Чингэлтэй дүүрэг 4-р хороо Бага тойруу 41 байр 39 тоот 40 м.кв талбайтай 3 өрөө орон сууц	71,040,760	Б.Цэрэнчунт 89086124
15	Баянгол дүүрэг 12-р хороо 6 бичил хороолол 13 байр 67 тоот 30 м.кв талбайтай 2 өрөө орон сууц	77,000,000	Б.Буянбадрах 89086144
16	Сүхбаатар дүүрэг 18-р хороо Сэлхийн зусланд байрлах 1400 м.кв газар	8,400,000	Ж.Оюунжаргал 89086119
17	Сүхбаатар дүүрэг 18-р хороо Сэлхийн зусланд байрлах 70 хувийн гүйцэтгэлтэй дутуу баригдсан 4 хувийн сууц	13,720,000	Ж.Оюунжаргал 89086119
18	Сүхбаатар дүүрэг 18-р хороо Сэлхийн зусланд байрлах 80 хувийн гүйцэтгэлтэй дутуу баригдсан 1 хувийн сууц	3,920,000	Ж.Оюунжаргал 89086119
19	Сүхбаатар дүүрэг 18-р хороо Сэлхийн зусланд байрлах дутуу баригдсан 7 ширхэг граш	4,970,000	Ж.Оюунжаргал 89086119
20	Сүхбаатар дүүрэг 18-р хороо Сэлхийн зусланд байрлах 1 ширхэг под станц	14,000,000	Ж.Оюунжаргал 89086119
21	Сүхбаатар дүүрэг 18-р хороо Сэлхийн зусланд байрлах 1 ширхэг 40 м гүний худаг	3,640,000	Ж.Оюунжаргал 89086119
<b>ХОЁР. ХАШАА БАЙШИН, ГАЗАР</b>			
22	Хан-Уул дүүргийн 13-р хороо 7-36а 11 тоот 700 м.кв эзэмших эрхтэй газар	2,846,690	Т.Адилбек 89086133
23	Сонгинохайрхан дүүрэг 32-р хороо Баруун туруун 3-31а тоот 49 м.кв хувийн сууц 388 м.кв өмчлөх эрхтэй газрын хамт	22,609,160	Т.Адилбек 89086133
24	Чингэлтэй дүүрэг 18-р хороо Яргайтын 42-р гудамж 7036 тоот байрлах 72 м.кв хувийн сууц, 402 м.кв талбайтай газрын хамт	12,863,761	Н.Өнөржаргал 89086120
25	Чингэлтэй дүүрэг 19-р хороо Доод салхит 5-р гудамж 95 тоот 212 м.кв талбайтай хувийн сууц, 700 м.кв газрын хамт	49,000,000	Б.Цэрэнчунт 89086124
26	Сонгинохайрхан дүүрэг 26-р хороо Мандал овоо 22 гудамж 12 тоот 60 м.кв талбайтай хувийн сууц, 513 м.кв талбайтай өмчлөх эрхтэй газар	42,000,000	Л.Уранбайгаль 89086129

№	Үл хөдлөх эд хөрөнгийн хаяг байршил	Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.4-д заасан санал болгох доод үнийг тохиролцсон болон үнэлгээчний тогтоосон зах зээлийн үнийн 50 хувь	Хариуцсан шийдвэр гүйцэтгэгч, утасны дугаар
<b>НЭГ. ОРОН СУУЦ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖ</b>			
1	Баянзүрх дүүрэг 2-р хороо Хоршоололын хотхон /13361/ Доржийн гудамж 13/5 байр 108 тоот 51,27 м.кв талбайтай 2 өрөө орон сууц.	42,297,750	Ц.Баянчимэг 89086179
2	Хан-уул дүүргийн 11-р хороо, Зайсангийн гудамж 54-р байрны 3 тоот 220,06 м.кв талбайтай орон сууц.	397,500,000	Ц.Баянчимэг 89086179
3	Хан-Уул дүүрэг 4-р хороо, Нүхтийн ам /17090/ Нүхтийн зам 19/09 тоот 437,2 м.кв талбайтай 80 хувийн гүйцэтгэлтэй дуусаагүй барилга, аялал жуулчлалын зориулалттай үл хөдлөх.	349,760,000	Ц.Баянчимэг 89086179
4	Хан-Уул дүүрэг 8-р хороо Төв аймаг явдаг замын зүүн талд байрлах 64679 м.кв, Г000300790 дугаартай эзэмших эрхтэй газар.	355,735,000	Ц.Баянчимэг 89086179
5	Эйр-Карго Монгол ХХК-ийн 10 хувийн хувьцаа, Иргэний нисэхийн ерөнхий газраас олгосон ачааны агаарын тээвэрлэгчийн ААТ-00 тоот тусгай зөвшөөрөл.	129,023,000	Ц.Баянчимэг 89086179
6	Хан-Уул дүүрэг 1-р хороо Жаргалант хотхон 1-р байр 19 тоот 209,9 м.кв талбайтай 5 өрөө орон сууц, зоорийн давхарт байршилтай 35 тоот 1 автомашины 18 м.кв зогсоолын хамт.	311,400,000	Ц.Баянчимэг 89086179
7	Хан-Уул дүүрэг 11-р хороо, Хөх тэнгэр цогцолбор Зайсангийн тойруу 46В байрны 09 тоот 214 м.кв талбайтай 5 өрөө орон сууц.	340,525,000	Ц.Баянчимэг 89086179
8	СХД 27 хороо, 21-р хороолол ХД46 дугаар байрны 23 тоот 53,7 м.кв талбайтай 2 өрөө орон сууц.	37,500,000	А.Осорбурам 89086176
9	Баянгол дүүргийн 19 дүгээр хороо, 4 дүгээр хороолол 51 дүгээр байрны 84 тоот 40 м.кв талбайтай 3 өрөө орон сууц.	44.000.000	Ж.Ариунзаяа 89086171
<b>ХОЁР. ХАШАА БАЙШИН, ГАЗАР</b>			
10	Баянзүрх дүүрэг 28-р хороо, Хужирбулан 1-р хэсэг 10-р гудамж 387 тоот байрлах 110 м.кв хувийн орон сууц, 700 м.кв гэр бүлийн хэрэгцээний газрын хамт.	17,500,000	О.Цэрэннадмид 89086163
11	Баянзүрх дүүрэг 28-р хороо, Хужирбулан 1-р хэсэг В100 /99/ 90 м.кв хувийн орон сууц, 504 м.кв гэр бүлийн хэрэгцээний газрын хамт.	13,500,000	О.Цэрэннадмид 89086163

## ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ҮНЭ ХАЯЛЦУУЛАХ ДУУДЛАГА ХУДАЛДАА

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас дараах хөдлөх хөрөнгийн үнэ хаялцуулах 2 дахь албадан дуудлага худалдааг 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 10 цагт албаны байранд зохион байгуулна. Оролцогчдыг 2017 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 14.00 - 17.00 цагийн хооронд Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны нэг цэгийн өрөөнд бүртгэнэ. Хугацаа хоцорсон

хүсэлтийн хүлээн авах боломжгүйг анхаарна уу.

Бүртгүүлэхээр ирэхдээ дуудлага худалдааны дэнчингийн мөнгийг Улаанбаатар банкны 2617001560 тоот дансанд тушааж нэг хувийг авчирна уу. Хаяг: Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, Үндсэн хуулийн гудамж-3, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба

ЦАХИМ ХАЯГ: <http://www.nshga.cd.gov.mn>,  
[www.facebook.com/pages/Нийслэлийн-Шийдвэр-Гүйцэтгэх-Алба](http://www.facebook.com/pages/Нийслэлийн-Шийдвэр-Гүйцэтгэх-Алба)

№	Хөдлөх хөрөнгийн нэр	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 64.4-д заасан тогтоосон үнээс 70 хувь	Тоо ширхэг	Хариуцсан шийдвэр гүйцэтгэгч, утасны дугаар	Эд хөрөнгө байгаа байршил
1	Hyundai Dumptruck маркын 1996 онд үйлдвэрлэгдсэн 2012 онд Монгол улсад орж ирсэн ногоон өнгийн ачааны автомашин	14,245,000	1	М.Нарантунгалаг 89086136	НШГА автозогсоол
2	Зил-130 маркын 1998 онд үйлдвэрлэгдсэн 2005 онд Монгол улсад орж ирсэн цэнхэр өнгийн ачааны автомашин	350.000	1	Б.Лочин 89086135	НШГА автозогсоол

## НИЙСЛЭЛИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБА

# ОНЦЛОХ ХУУДАС

Speak out

## ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЭРХ МЭДЛИЙГ ХЯЗГААРЛАХ НЬ БУРУУ ШИЙДВЭР



### МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Н.БАТЗАЯА

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажил орон даяар өрнөж буй. Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр нийт 32 заалтыг шинэчлэнэ. Тодруулбал, УИХ-тай холбоотой найл, Ерөнхийлөгчтэй холбоотой дөрөв, Засгийн газартай холбоотой гурван, шүүх эрх мэдэлтэй холбоотой дөрөв, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжтэй холбоотой 10, төрийн албатай холбоотой гурван зүйлд өөрчлөлт оруулахаар ард иргэдийн дунд санал асуулга явуулж байгаа билээ. Үүнээс Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хязгаарлах тухай асуудал олон нийтийн анхаарлыг ихээхэн татаж байна. Уг асуудалтай холбогду олон иргэдийн байр суурийг сонч, "Speak out" бэлтгэлээ.



**Г.Цоож:** Өөрсдийгөө хамгаалахын тулд Ерөнхийлөгчийн эрхийг хязгаарлаж байна

*/Баянзүрх дүүргийн иргэн/*

-УИХ-аас Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар болсон. Өөрчлөлт оруулах заалтыг нь сонссон. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хязгаарлах хэд хэдэн заалт байна билээ. Гэхдээ би энэ шийдвэрийг буруу гэж боддог. Энэ ажлыг МАН л хийж байна. Тэд буруу зүйл хийвэл Ерөнхийлөгч эсэргүүцэх учраас өөрсдийгөө хамгаалж байгаа юм. Тийм зорилгоор л Ерөнхийлөгчийн эрхийг хасч байна. МАН ялалт байгуулсан нь их буруу алхам болсон. Би саналаа өгсөн л дөө. Гэхдээ буруу шийдвэр гаргасан гэдгээ ойлгосон. МАН-д саналаа өгсөн биш бидний төлөө ажиллах нь битгий хэл Ерөнхийлөгчийн эрхийг хасахаар ажиллаж байна. Тэд өөрсдөө эрх чөлөөтэй. Ямар ч хууль байсан батлаад гаргадаг. Ард иргэдийнхээ төлөө хийж байгаа зүйл гэж алга. "Насны хишиг"-т 65-аас дээш гээд нас зачихсан. 60 хүрээд тэтгэвэрт гарсан хүмүүс тэтгэврийн нэмэгдэл байхгүй. 65 хүрч байгаад насны нэмэгдлээ авна. Энэ мэтчилэн буруу зүйлийг МАН-ынхан их хийж байгаа юм. Өөрсдийнхөө эрх ашгийг хамгаалах хууль гаргахаар зүтгээд байна. Үүнийг хэлэхэд энэ асуудалд Ерөнхийлөгч ганцаардаад байна л даа.



**Ю.Эрдэнэбаяр:** Ерөнхийлөгчийн эрхийг хязгаарлавал Монгол утгаа алдана

-Миний бодлоор Ерөнхийлөгчийн эрх мэдлийг хязгаарлана гэдэг буруу. Хэрвээ Ерөнхийлөгчийн бүрэн эрх мэдлийг нь хязгаарлах л юм бол Монгол Улс утгаа алдана. Энэ их ойлгомжтой зүйл шүү дээ. Одоогийн парламентын олонхийг МАН бүрдүүлж байна. Үүнээс харахад бүх зүйл ойлгомжтой болно.



**Ү.Цолмон:** Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь зөв

*/Баянзүрх дүүргийн иргэн/*

-Үндсэн хуулийн өөрчлөлтөд Ерөнхийлөгчийн бүрэн эрхтэй холбоотой асуудал орсон байна билээ. Энэ бол хэцүү асуудал. Яагаад гэвэл одоогийн эрх мэдэл нь тийм ч их биш. Бараг эрх мэдлийг нь хязгаарлаад бэлгэдлийн чанартай болгох гэж байгаа юм шиг санагдсан. Миний мэдэхээр Ерөнхийлөгчийн хууль санаачлах, Засгийн газарт чиглэл өгөх эрхийг хязгаарлах юм билээ. Уг нь нэг нам хэт олон суудалтай байгаа үед Ерөнхийлөгчийн эрхийг хязгаарлах нь буруу болов уу. Ерөнхий сайд, УИХ гээд бүх л газар МАН-ын гишүүд бий. Миний бодлоор дэмий л гэж бодож байна. Яах вэ, Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь зөв л дөө.



**Ж.Өсөхбаяр:** Ерөнхийлөгчийн эрхийг хязгаарлах нь буруу

*/Сүхбаатар дүүргийн иргэн/*

-Үндсэн хуулийн өөрчлөх нь зөв. Яагаад гэвэл 20 гаруй жилийн өмнө баталсан хууль учраас одоогийн нийгмийн нөхцөл байдалтай таарахгүй зүйлс бий гэж бодож байна. Гэхдээ Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хязгаарлах тухай асуудлыг ч тусгасан байна билээ. Энэ бол буруу. Ер нь манай улсын Ерөнхийлөгчид нэг их эрх мэдэл байдаггүй шүү дээ. Өмнөх Ерөнхийлөгчдийн түүхээс харахад сүртэй хийсэн зүйл байдаггүй. Бусдын шийдвэрт сүртэй нөлөөлсөн зүйл ч байхгүй. Үүнээс харахад эрх мэдлийг нь хязгаарлаад ч нэмэргүй биз. Яах вэ, зарим хүмүүс одоогийн парламентад нэг ном хэт олон суудалтай байгаа учраас Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хязгаарлах нь буруу гэж үзэж байгаа юм билээ. Нэг талаас харахад энэ бас байж болох л хувилбар.



**Э.Баярсүх:** Үндсэн хуулийг өөрчлөх цаг нь биш

-Үндсэн хуулийн өөрчлөлтөд Ерөнхийлөгчийн бүрэн эрхтэй холбоотой заалт орсон гэсэн. Энэ талаарх мэдээг үзсэн юм байна. Одоо бол Монгол Улсын Ерөнхийлөгч хууль санаачлах эрхтэй. Уг эрхийг нь Үндсэн хуулийн өөрчлөлтөөр болиулах гээд байгаа юм билээ. Энэ бол буруу л гэж бодож байна. Одоо МАН парламентад олон суудалтай. Тэд өөрсдийнхөө эрх ашгийг бодсон шийдвэр их гаргаж байна. Үүний эсрэг нэг хүн байх ёстой. Би хувьдаа зөвшөөрөхгүй байгаа. Үндсэн хуульд ч өөрчлөлт оруулаад хэрэггүй юм шиг. Бид угаасаа л энэ Үндсэн хуулиа дагаж, мөрдөж ирсэн. Хэзээ нэгэн цагт дахин өөрчлөх байх. Тийм шаардлага ч гарах болов уу. Гэхдээ тэр үе нь одоо биш юм болов уу гэж би харж байгаа. Дэндүү хэсэг бүлэг хүмүүсийн эрх ашигт нийцүүлэх гээд байгаа юм шиг л санагддаг.



**Г.Гэрэлмаа:** Үндсэн хуулийг өөрчлөхөөр яарч байгаа нь сонин

*/Сонгинохайрхан дүүргийн иргэн/*

-Миний хувьд Үндсэн хуульд өөрчлөлт оруулахыг тийм ч сайнаар хүлээж авахгүй байгаа. Ямар учраас Үндсэн хуульд өөрчлөлт оруулах гээд байгаа нь тийм ч тодорхой биш. Ард иргэддээ ч сайн таниулахгүй байна шүү дээ. Зуд ган гачиг болно гэж анхааруулаад байхад хууль өөрчлөхөө урьтал болгох юм. Их сонин. Ерөнхийлөгчийн эрх мэдлийг хязгаарлана гэдэг намын нь эрх ашиг, үзэл бодол байх гэж боддог. Зарим хүмүүс МАН үнэмлэхүй ялалт байгуулж, 57 суудал авсан. Ингэснээр өөрсдийн үзэл бодол, эрх ашигт нийцүүлэн хууль баталлаа гэж ярьж байна. Энэ хоёр талтай л даа. Манай иргэд бас нэг зүйлд хэтэрхий туйлширч болохгүй. Яах вэ нэг

талаас нь харахад тухайн намын эрх ашиг байж болох юм. Гэхдээ нөгөө талаас нь харвал мнголчуудын цаашдын амьдралтай холбоотой асуудал. Тиймээс л бид үүнд нухацтай хандах ёстой. Төрөөс ч ард иргэддээ яг ямар ямар зүйлд өөрчлөлт оруулах гээд байгаагаар сайн тайлбарлаж, таниулах ёстой. Өнөөдөр Монгол Улсын Үндсэн хуулийн ямар ямар заалтад яаж өөрчлөлт орох гээд байгааг мэдэхгүй олон хүн гудамжаар алхаж байгаа шүү дээ. Манайханд нэг дутагдал байдаг. Хууль хэлэлцэхдээ тухайн хуулийнхаа талаархи мэдээллийг иргэддээ хангалттай хүргэж чаддаггүй. Тэгээд иргэд нь хуулиа сайн мэддэггүй.



**Т.Наранцэцэг:** Ерөнхийлөгчийн эрхийг хязгаарлахыг дэмжихгүй

*/Налайх дүүргийн иргэн/*

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах болсон талаар сонссон. Миний бодлоор Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хязгаарлах нь буруу. Яагаад гэвэл Ерөнхийлөгч тодорхой хэмжээнд Засгийн газрын шийдвэрт нөлөө үзүүлдэг. Хэрвээ Ерөнхийлөгчийн энэ эрхийг хасчихвал

МАН өөрийн эрх ашгийн төлөө ажиллаж эхэлнэ. Одоогийн парламентад МАН хамгийн олон суудал авсан байгаа шүү дээ. Тэгэхээр Үндсэн хуулийн өөрчлөлтийн Ерөнхийлөгчтэй холбоотой заалт ч тэд өөрсдийнхөө эрх ашгийг хамгаалахын төлөө хийж байгаа гэж боддог.

## ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

## ТУУЛГОЛ



Б.ДАВААХҮҮ

Урин дулааны улиралд нийслэлчүүд Туул голын эрэг орчимд аларч зугаалдаг. Гэвч, голын эрэг орчимд орох гарах гарч, зориулалтын хогийн цэг, нийтийн бие засах газар байхгүй учир эдгээ "Хатан Туул" маань хогийн цэг болж хувираад байгаа юм. Хайхрах эзэнгүй, сайн дурынхнаас өөр цэвэрлэх хүнгүй болохоор төрөөс оновчтой шийдвэр, бодлого нэхэж байна. Тиймээс энэ асуудлыг хөндөн "Монголын мэдээ" сонин "Дугаарын сурвалжлага"-аа бэлтгэлээ.

## Хогон дундах амралт

Уд хэлбийсэн үе. Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Маршалын гүүрнээс зүүн тийш Туул голын өмнөд эрэг хөлхөдөлгөөнийхтэй. Төрөл бүрийн маркийн машинууд хайршиг байрлах бөгөөд тэдгээр машинуудын сүүдэрт хүмүүс хэсэг бүлгээрээ тойрон сууж, зарим нь өмсөж ирсэн хувцсаа өдрийн ажлын ачаалалтайгаа хамт тайлж орхиод нарны илчинд бүлээсэн голын усан дотор чанга чанга инээлдэн нэг нэг рүүгээ ус цацан хөгжилдөх аж. Харин зарим нь хөвөр тоглож, нэгнийхээ яриаг чих тавин чагнаж, үе үеэн инээх бол зарим нь голын эргийн бүлээсэн чулуунд дэвссэн гудсан дээр дээш харан хэвтэж байлаа. Гэвч, хаа сайгүй хог. Голын эрэг хавнар, бургасны орчимд, тэр бүү хэл гол дотор хог хөглөрнө. Салхи үл ялиг эвшин үлээх тоолонд хаа нэгтэйгээс муудсан махны өмхий, гашилсан, нэхсэн зүйлийн таагүй үнэр хамар цоргиж байлаа. Гэсэн ч, амрагчид тэр үнэрийг үл хайхрах ажээ. Голын уснаас таван алхмын зайд байрлуулсан суудлын машиныхаа сүүдэрт

өнөөх өмхий үнэрийг үл тоон усны урсгал харан үдийн цайгаа ууж суух нэгэнтэй ч таарсан юм. Сонгинохайрхан дүүргийн иргэн О.Мөнхтамир гэх хөрслог бор царайтай залуу ажлын ачааллаа тайлж, түрхэн ч атугай хотын их чимээнээс холдохын тулд тэнд очжээ. "Туулын эрэгт хааяа ирж амардаг. Гэхдээ энд бол анх удаагаа л ирж байна" хэмээн аядуу намуухан дуугаар ярих тэр залуу тулгарч буй бэрхшээлийн тухай ярихдаа "Хог, хаягдлын асуудал хүнд байгаа. Шууд хүний ухамсаргүйгээс гэж хэлж чадахгүй нь. Хогоо ил задгай хаях, ууталсан атлаа амарсан газраа орхиод явах нь хүний ухамсаргүй, харуцлагагүй байгаатай л холбоотой. Гэхдээ хог хаях нэгдсэн цэг байгуулчихвал амрагчид ил задгай хог хаяхаа болих байх гэж бодож байна. Ер нь аливаа зүйл хоёр талтай байдаг шүү дээ. Хоггүй л байвал өөр асуудал уг нь алга даа" хэмээлээ.

Түүнээс хоёр алхмын зайд мөн Сонгинохайрхан дүүргийн иргэн Б.Даваалхагва гэр бүл, найз нөхдийнхөө хамт байрлажээ. Голын усанд гурван настай болов уу гэмээр бяцхан охиноо тоглуулж байгаад эрэг дээр дөнгөж гарч ирмэгц нь өнөөх хог хаягдал, түүний

гарц шийдлийн талаар ямар бодолтой байгааг нь тодрууллаа. Тэрбээр "Голын эрэг орчмоор хогийн сав байршуулчихвал уг нь зүгээр байна. Хогийн савтай болчихвол ядаж ойр орчмын хогны асуудал цэгцрэх байх. Гэхдээ хэн цугласан хогийг зөөж хаях вэ гэдэг бас асуудалтай. Өдөртөө л дүүрэг болов уу. Нөгөөтэйгүүр, иргэд ухамсаргүй байна. Аваад ирж болсон юм чинь хогоо буцаагаад аваад явж яагаад болохгүй гэж" гэлээ. Ийн хэлэхэд нь саяхан л гол дотор тоглон инээж байсан түүний царай барайж, яриа нь түргэсч, дуу нь чангарч байсан юм. Б.Даваалхагвынхны байрласан газартай бургас хаяа дэрлэх бөгөөд тэр хэсгээс "хогийн цэг" эхэлнэ. Угтаа Туул голын эрэг орчимд тусгайлан хогийн цэг гэж үгүй. Гэвч, бургастай хэсэг тэрхүү "хогийн цэг"-ийг орлох болжээ. Ажлын ачааллаа

тайлж, усны урсгал сонсон амрах гэсэн хүсэл үнэндээ Туул гол дээр очингуут л эмзэглэл, эгдүүцэл, харамслаар солигдох нь тэр. Туул гол тэр чигээрээ хогонд дарагдаж, тэнд очихын аргагүй муухай болчихож. Болчихож гэж дээ болгочихож. Өмнө нь хүмүүс буудалласан бололтой шатаж дууссан модны үнс, цагаан гялгар уутанд хийж амыг нь боосон хог, архины шил, том пивоны сав, хөндсөн талх, талласан аргасгүи муухай болчихож. Мэт мэт овоолсон хогноос бургас эхэлж байв. Бургасны сүүдэрт бусдын хаясан хогийг дэрлэх шахам ойрхон зайд согтуу эр унтаж байлаа. Түүнээс холгүй зайд нэгэн гэр бүл гудас дэвсэн нарлаж байв. Шуудхан хэлэхэд, тэд хогон дунд амарч байсан юм.

## "Хоггүй газар алга"

... Энэ үгийг тортой хувцас гартаа барьж, нэгэн хэвийн хурдан хэмнэлээр алхах Баянзүрх дүүргийн иргэн М.Мөнхбаяр хэлэв. Тэрбээр Туул голын эрэгт амрах санаатай иржээ. Гэсэн ч, хоггүй цэвэрхэн газар хайгаад олоогүйгээ учирлаж байлаа. М.Мөнхбаяр "Гол дээр ирсэн чинь дан л хог байна. Болиод өөр тийшээ явах санаатай. Уг нь салхинд гарангаа голын захад жаахан хэвтэе гэж бодсон юм. Гэтэл хог ихтэй болохоор суух газар ч олдохгүй нь. Үнэр танар нь ч дийлдэхгүй юм байна. Сая нэг газар жаахан суух гэсэн нил хог. Уг нь сайн дурынхан, залуучууд зөндөө л цэвэрлэдэг биз дээ. Яг хаагуураа цэвэрлэдэг байдаг юм бол. Иргэдийн ухамсар үнэхээр

муу байна" гэж яваан дундаа ярьсаар голын захад холгүй тавьсан машин руугаа яарсаар одлоо. Туулын бургасны хэсэгт тав алхаад л овоолсон хог таарах ажээ. Нөгөөх л нэг удаагийн аяга таваг, ариун цэврийн цаас, мөлжсөн яс, сүүний сав, архи пивоны шил гялгар уут, бүр таавчик, гутал, сандаал, эмэгтэй хүний хөхөвч, хэрэглэсэн бэлгэвч гэх мэт хүний санаанд оромгүй элдэв хогийг тэнд хаяжээ. Бургасны гол хэсэгт хаалгыг нь иртэй зүйлээр эвдэж, шатаасан болов уу гэмээр сэйф, шар өнгийн чөмөд, улстөрчдийн сонгуулиар тарааж байсан сэтгүүл зэргийг ч хаясан байв. Амрагчдын хүндэрсэн ялгадас, хэрэглэсэн ариун цэврийн цаас ч энд тэндгүй хөглөрч байлаа.

## "Туулын эрэгт биш хогийн цэгийн хажууд амарч байгаа юм шиг л байна"

Туул голын эрэгт майхнаа хатгаж, ойр орчмын хогийг нь цэвэрлэн хоёр уутанд хийж, майхныхаа хажуугийн бургаснаас дүүжилсэн хосууд мөн тэнд амарч байх аж. Эрэгтэйг нь Н.Эрдэнэдорж гэдэг. Тэрбээр Чингэлтэй дүүргийн иргэн. Найз бүсгүйнхээ хамт голын захад амрахар сайхан төсөөлөлтэй ирсэн ч, бодсоноос хавьгүй аймшигтай дур зураг угтсан тухай Н.Эрдэнэдорж хуучиллаа. "Гол орчмын хог хаягдал үнэхээр хэцүүхэн байна.



## АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Ашигт малтмалын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, 34.6, 34.7 дахь хэсэгт заасны дагуу тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг алдангийн халт төлөөгүй, мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтыг зөрчсөн дараах аж ахуйн нэгжийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.2 дахь хэсэгт заасныг үндэслэн АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2017 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 486 дугаар шийдвэрээр цуцалсныг мэдэгдэж байна.

№	Тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар	Анх олгосон огноо	Аймаг, хот	Сум, дүүрэг	Талбайн нэр	Аж ахуйн нэгжийн нэр
1	XV-019931	2016.05.09	Дорнод	Баян-Уул, Цагаан-Овоо	Уулс-2	Универсалнoble химикал ХХК
2	XV-019486	2016.05.16	Дорнод	Баяндун	Дун-2	Универсалнoble системс ХХК
3	XV-019803	2016.05.16	Дорнод	Дашбалбар	Даш-3	Универсалнoble линк ХХК
4	XV-018356	2015.06.09	Увс	Өлгий, Өмнөговь	Сэрүүн	Эс И И Дн ХХК
5	XV-018414	2015.06.09	Увс	Өмнөговь	Өмнөговь	Зэс-Аранзан ХХК
6	XV-018282	2015.06.11	Завхан	Завханмандал, Сантмаргаз	Элст	ДУО ХХК
7	XV-018604	2015.06.15	Увс	Өлгий	Цахир-2	Багадеш ХХК
8	XV-018310	2015.06.15	Увс	Өмнөговь	Орлого	АСУМО ХХК
9	XV-018358	2015.06.15	Увс	Наранбулаг	Дунд	АСУМО ХХК
10	XV-017950	2015.06.15	Увс	Малчин	Тал	АСУМО ХХК
11	XV-020413	2015.06.15	Увс	Өмнөговь	Орлого	АСУМО ХХК

12	XV-020412	2015.06.15	Увс	Өмнөговь	Орлого	АСУМО ХХК
13	XV-020414	2015.06.15	Увс	Өмнөговь	Орлого	АСУМО ХХК
14	XV-018326	2015.06.15	Увс	Өлгий	Өгөөмөр	Есон хүлэг майнинг ХХК
15	XV-018661	2016.06.16	Увс	Өлгий, Өмнөговь	Цахир-1	Отгонтбогд ХХК
16	XV-018631	2015.06.19	Увс	Наранбулаг	Улаан	Талстминерал ХХК
17	XV-018752	2015.06.22	Говь-Алтай	Халиун	Даваа	Платин энержи ХХК
18	MV-001701	1999.06.22	Булган, Орхон	Орхон, Жаргалант	Чингэлийн голын хөндлөн намаг	Отгонтэнгэр-Оргил ХХК
19	XV-018481	2015.06.26	Өвөрхангай	Баянгол	Бургаддай	Глобалвалю майнинг ХХК
20	XV-018811	2015.06.26	Говь-Алтай	Дэлгэр	Хөндий	Хэмжээшгүй-Орд ХХК
21	XV-018955	2015.06.29	Хэнтий	Жаргалтхаан	Улаан өндөр	Лотусбаялаг флурспар ХХК
22	MV-015606	2010.06.29	Увс	Хяргас	Шар уул	Хорикаваметалл ХХК

## АМГТГ-ЫН КАДАСТРЫН ХЭЛТЭС

# ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

# УЛААНЧУЛУУТЫН ХОГИЙН ЦЭГ БИШ

Бид хоёр энэ хавийн хогийг цэвэрлэсэн юм. Бүгд л амарч байна, гэхдээ хогоо шуудайндаа хийгээд аваачаад хаячих л даа. Туулын эрэгт биш, хогийн цэгийн хажууд амарч байгаа мэт онцгүй санагдаж байна. Гоё газар байна. Гэсэн ч, хог нь дийлдэхгүй юм. Би аймаар газар үзүүлье” гээд тэрбээр майхнаасаа гарч, урагш 10



маршрутдаа тусгаад долоо хоногтоо эсвэл өдөртөө хогийг нь тэвэрлэхдэг болох юм. Хөтөлбөрт тусгагдсаны дагуу тодорхой хугацааны дагуу орон нутгийн төсөвт баглуулсны дараа хэрэгжүүлнэ. Гэхдээ энэ оны төсөвт багтаагдсан учраас энэ жилийн тухайд хэрэгжих боломжгүй. 2018 оны төсөвт тусгагдчихвал, голын эрэг орчимд бие засах газартай, хогийн цэгтэй болно. Ингэснээр ил задгай хог хаях нь багасах байх. Мөн хүн олноор цуглардаг хэсгүүдийг судалж, тохижилт хийх төлөвлөгөө бий” гэлээ. Гэхдээ нийслэлээс хэрэгжүүлэхийг зорьж буй хөтөлбөр анхны удаагийнх биш. Өмнө нь 2010 онд “Сэлбэ голын урсацыг нэмэгдүүлэх, орчныг нь тохижуулах” төсөл нийслэлийн санаачилгаар хэрэгжиж байсан ч, өнөөдөр 350 метр газар тухайн хөтөлбөр нэртэй сураг алдарсан юм. Ямартай ч, Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр тун удахгүй батлагдах нь. Гэхдээ ирэх оноос нааш хэрэгжих боломжгүй тул энэ жилдээ Туул гол хайхрамжгүй, хариуцлагагүй иргэдийн хаясан хогонд “дарлуулж”, хэн нэгэн сайхан сэтгэлтэн ирж цэвэрлэхийг хүлээн бүтэн жилийг үдэхээс өөр сонголтгүй аж. Уг нь Туул голын эрэг тусгай хамгаалалтын бүс байх учиртай. Гэтэл дэгсдүүлж хэлбэл, Улаанчулуутын хогийн цэгээс дутах юм алга. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сайн дурынхан, албан байгууллага, дүүргийн Засаг даргын Тамгын газраас санаачлан голын эрэг хавиас хэдэн тонн хог цэвэрлэлээ гэх мэдээлэл өдөр тутамдаа л сонсогддог. Гэтэл цэвэрлээд байхад хүчрэгдэхгүй байна гэхээр нийслэлчүүд ямар их тог тарьдаг нь ойлгомжтой болов уу. УИХ-ын хаврын чуулганаар Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Уг хуульд хог хаясан хүмүүст хариуцлага тооцох хуулийн “чанга” заалтууд тусгагдсан байгаа. Тодруулбал, уг хуулийн 41.13 дахь заалтад хог хаягдал хаяж байгаа тухай мэдээллийг холбогдох байгууллагад нь өгч, тухайн асуудал нь баталгаажсан тохиолдолд мэдээлэл өгсөн иргэн хог хаясан байгууллагын торгуулийн дүнгийнх нь 15 хувьтай тэнцэх мөнгөн урамшуулал авах урамшууллын системийг тусгаж өгчээ. Харин иргэн, аж ахуйн нэгжийн хог хаяхдаа хэрэглэсэн тээврийн хэрэгслийг хурааж, зөрчил гаргасан хүнийг нэг сая төгрөг, хуулийн этгээдийг гурван сая төгрөгөөр торгох, нийтийн эзэмшилд зар сурталчилгаа байршуулах, шашны болон зан үйлийн эд зүйлс тавьж хог хаягдал үүсгэхийг хуулиар хориглож өгсөн байна.

орчим метрийн зайтай бургас руу алхлаа.

Улмаар “Энд хонины мах өмхийрч байна. Салхи салхилмагц үнэр танар нь дийлдэхгүй болж байна” гээд бургас дотор овоолсон хогийг заав. Түүний хэлсэнчлэн, шар шуудайны хэлтэрхий дээр түүхий махны өөх, шулсан булууны яс, сэмжний өөх, сүүд, хоол амтлагчны уут тэргүүтнийг хаясан байлаа. Мах, өөх нь ногоорч, ялаанууд дүнгэнэлдэн нисэх бөгөөд ойролцоо мөн тагтаа хөгцөрсөн талхны булан, хоолны үлдэгдлийг тоншиж байх аж. Н.Эрдэнэдорж “Ийм л байна” хэмээн мөрөө хавчиж хэлээд толгойгоо сэгсэрлээ. Мөн үргэлжлүүлэн “Зарим нь зориуд хогоо авчирч хаяж байх шиг. Амарч болно, байрласан газраа цэвэрлэхдэг бол дараагийнх нь хүн ирээд л амарна шүү дээ. Болдог бол машин орж ирдэг замын ойролцоо нэгдсэн хогийн цэг байгуулчихвал асуудал хамаагүй цэгцрэх юм шиг санагдаж байна. Бид хогоо машиндаа өмхийрүүлээд гэртээ аваачиж хаяхгүй нь ойлгомжтой. Ядаж нэг цэг байгуулчихвал ууттай хогоо замдаа шидчихээд явна шүү дээ. Бид соёлт нийгэмд амьдарч байгаа. Боловсон амьдарч, амрах эрхтэй бид дээ. Хогоо хаяхгүй байх нь иргэний үүрэг. Гэтэл түүнийгээ аваачаад хаях цэг алга. Ядахдаа байрнуудын голд байдаг шиг пунктер тавих хэрэгтэй. Тэгэхгүй бол нийслэлчүүд биднийг ундаалж байгаа энэ гол хогноос болж, ичсэндээ ширгэх вий дээ” хэмээн халаглалаа.

Хэнтийн Хагийн хар нуураас эх авч Улаанбаатар хотоор дамжин Орхон голд цутгадаг Туул гол нийт 704 км урт замыг туулдаг. Түүний багахан хэсэг нь Улаанбаатар хотын тэг дундуур дайран өнгөрдөг ч Туулд хамгийн халтай хэсэг нь энэ билээ. Амрагчдын хариуцлагагүй байдал, оновчтой хот төлөвлөлтгүйгээс болж эдүгээ “Хатан туул”, “Хогон” Туул болж, хэн нэгэн сайн дураараа ирж цэвэрлэхийг хүлээн өмхийрч муудсан

хогоо дааж ядан уйтгартайгаар урсана. Гэвч, Туулыг зорих хөл тасарсангүй. Машинууд ар араасаа цувран ирсээр байх ажээ.

## БОАЖЯ: Орон нутгийн захиргаа хогны менежментийг хариуцах ёстой

Туул голын эрэг орчим хогон овоо болж буй эл асуудлыг хэн хариуцаж, хэрхэн шийдвэрлэх талаархи гарц гаргалгааг хайж Байгаль орчин аялал жуулчлалын яамыг зорилоо. Тус яамны хэвлэлийн төлөөлөгч Д.Мягмардорж “Туул голын сав газрын захиргааны оролцоо байх нь байна. Гэхдээ Хог хаягдлын тухай хуульдаа тухайн орон нутгийн засаг захиргаа хогны менежментийг хариуцах ёстой гэж заасан байгаа. Яам бодлого л тодорхойлно” гэх товчхон хариулт өгсөн юм. Харин Туул голын сав газрын захиргааны менежмент төлөвлөлтийн албаны дарга Х.Түвшинбаяр хогийн цэг, бие засах газар байгуулах нь бидний ажлын чиг үүрэг биш гэх хариулт өгч байлаа. Тэрбээр “Уг нь Туул голын сав газрын захиргааны чиг үүрэг нь хог цэвэрлэх биш шүү дээ. Туул гол Баянзүрх, Хан-Уул зэрэг хэд хэдэн дүүргийн нутаг дэвсгэрт хамаарна. Үүнийг нийслэл, дүүрэг хариуцах учиртай. Дүүрэг бүр өөрсдөө ТҮК-тай. Хогны асуудлыг шийдэх боломж бий. Манайд бие засах газар, хогийн цэг байгуулах төсөв ч байдаггүй” гэсэн юм. Туул голын сав газрын захиргаа нь гурван аймаг, нийслэл хотоор дайран урсах 704 км урт Туулын сав газрын усны нөөцийн хомсдол, бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх орон нутгийн болон салбар дундын зохицуулалтыг хангах усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэгтэй аж. Х.Түвшинбаяр ч тус байгууллага 10 гаруй хүний бүрэлдэхүүнтэй,

дээр нь голын орчимд хог хаяж, бохирдуулж буй иргэдийг торгох ямар нэг эрх үүрэггүй гэдгийг тодотгож байсан юм. Гэсэн ч, байгууллага аж ахуйн нэгжүүдтэй хамтран нийтийн хог цэвэрлэгээг өнгөрсөн гуравдугаар сараас хойш зохион байгуулжээ. Туул гол дагуу үйл ажиллагаагаа явуулдаг АПУ, III, IV цахилгаан станц, Цахилгаан дамжуулах сүлжээ компани зэрэг 25 байгууллага, аж ахуйн нэгжтэй нийлж, өнгөрөгч гуравдугаар сараас хойш давхардсан тоогоор 54.1 км талбайгаас 200 орчим тонн хог цэвэрлэсэн байна. Энэ ажилд нийтдээ 3240 хүн оролцжээ. Мөн Х.Түвшинбаяр байгууллагууд санаачилгаараа хогийн сав тавьдаг ч, ойролцоох айлууд хулгайлах, мал эвдэх тохиолдол гарахаас гадна дүүргүүдийн ТҮК-ийн тогтсон маршрут байдаггүй учраас хогийг зөөж асгахад хүндрэл учирч байгааг учирлаж байлаа.

## Дэд хөтөлбөр хэрэгжихийг хүлээх Туул

Үүний дараа Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Гохжилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Аригунтай уулзлаа. Тэрбээр 2017-2020 он хүртэлх Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр боловсруулсанаа дуулгасан юм. Тус хөтөлбөр тун удахгүй батлагдах бөгөөд нийтдээ есөн зорилттой гэнэ. Үүнд, Туул, Сэлбэ зэрэг гол дагуух хэсгийг хог хаягдалгүй болгох, хог хаягдлын менежментийг сайжруулах том зорилт багтаж байгаа юм байна. С.Аригунтай хэлэхдээ, “Хөтөлбөрийн хүрээнд эмх замбараатай амралт зугаалгын бүсийг бий болгоно. Машин орж гарах гарцтай болгохоос гадна хогийн зориулалтын цэгийг улирлын чанартай байршуулдаг байх зэрэг арга хэмжээнүүдийг төлөвлөсөн. Ингэснээр тухайн хогийн зориулалтын цэгээс хариуцсан дүүргийн ТҮК

## АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Ашигт малтмалын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, 34.6, 34.7 дахь хэсэгт заасны дагуу тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг алдангийн хамт төлөөгүй, мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтыг зөрчсөн дараах аж ахуйн нэгжийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.2 дахь хэсэгт заасныг үндэслэн АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2017 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн 477 дугаар шийдвэрээр цуцалсныг мэдэгдэж байна.

№	Тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар	Анх олгосон огноо	Аймаг, хот	Сум, дүүрэг	Талбайн нэр	Аж ахуйн нэгжийн нэр
1	XV-018384	2015.05.21	Увс	Наранбулаг	Тогтох	Биздели ХХК
2	XV-018295	2015.05.22	Ховд	Алтай	Цахир	Эс Жи Эйч ХХК
3	MV-017032	2012.05.22	Төв	Алтанбулаг	Налгар	Ти Эн энд Юу ХХК
4	MV-017209	2012.05.22	Төв	Алтанбулаг	Налгар	Эм-Капитал ХХК
5	XV-018145	2015.05.22	Увс	Өмнөговь	Салхит	Лалисланд ХХК
6	MV-014849	2007.05.23	Хэнтий	Цэнхэрмандал	Хадагтай	Зулмөнх бадмаарга ХХК
7	XV-018171	2015.05.25	Ховд	Алтай	Цахир хоолой	Дийпсүрвэй ХХК
8	XV-018543	2015.05.28	Увс	Өмнөговь	Ёл	Багадөш ХХК
9	XV-018584	2015.05.28	Баян-Өлгий	Алтанцогц, Баяннуур	Дов	Цагаантамич ХХК
10	XV-018279	2015.05.28	Ховд	Алтай	Хайст	Эн Си Ар ХХК
11	XV-018167	2015.05.28	Баянхонгор	Баянцагаан	Цагаантолгой	Эн Си Ар ХХК
12	XV-018530	2015.06.02	Өмнөговь	Булган	Мушгива	Баялаг эрдэс цогт ХХК
13	XV-013903	2008.07.21	Дархан-Уул	Хонгор	Могойт	Зууны төгөл ХХК
14	XV-019670	2016.06.03	Хэнтий	Бор-Өндөр, Дархан	Хүрэн толгой	Амадеусмонгол ХХК
15	XV-019616	2016.06.03	Булган	Бүрэгхангай	Дэнж	Максүүр транс ХХК
16	XV-018375	2015.06.04	Увс	Өмнөговь	Өмнөговь	Эн Си Ар ХХК
17	MV-013785	2008.06.05	Хэнтий	Мөрөн	Худгийн ам	Монголиан айрон групп ХХК
18	XV-018376	2015.06.08	Өмнөговь	Баяндалай	Одод	Глобал майнинг менежмент консалтинг ХХК

АМГТГ-ЫН КАДАСТРЫН ХЭЛТЭС

